




ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ

Эрчим хүчний сайдын 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 01/01 дугаар тушаалын 7 дугаар хавсралт



№11.1.7 ДУЛААНЫ ШУГАМ СҮЛЖЭЭ, ДУЛААН МЕХАНИКИЙН ТОНОГЛОЛ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН УГСРАЛТЫН АЖЛЫГ ШАЛГАХ ХЯНАЛТЫН ХУУДАС

Хяналт шалгалтын төрөл:

Хяналтын байгууллага:

Шалгуулагч этгээдийн нэр:

Объектын нэр:

Регистрийн дугаар:

Удирдамжийн дугаар:

Хяналт шалгалт хийсэн огноо:

Шаардлага хангасан асуултын тоо:

Хууль сахин мөрдөлтийн хувь:

Шаардлага хангаагүй нийт оноо:

Эрсдэл үүсэх магадлалын хувь:

Эрсдэл үүсэх магадлал

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АСУУЛТУУД, ҮНЭЛГЭЭ

№	Хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын нэр, зүйл, заалт	Асуултууд	Батлагдсан оноо		Авсан оноо	Гүйцэтгэлийн шалгалт
			Шаардлага хангасан	Шаардлага хангаагүй		
1		2	3	4	5	6
Баримт бичгийн бүрдүүлэлт болон үндсэн үйл ажиллагаатай холбогдсон асуултууд			0	225	0	0
1	Барилгын тухай хуулийн 19 дүгээр зүйл 19.1.1	Зураг төсөл зохиогч байгууллага зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөлтэй.	0	30		
2	Эрчим хүчний тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.11	Эрчим хүчний барилга байгууламж шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн угсралтын ажил гүйцэтгэгч байгууллага тусгай зөвшөөрөлтэй.	0	30		
3	Барилгын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 заалт болон 25 дугаар зүйл	Дулааны шугам сүлжээ, тоноглол, тоног төхөөрөмжийн зураг төслийг боловсруулахдаа эрх бүхий байгууллагаас олгосон газрын зөвшөөрөл, зургийн даалгавар, норм, нормативын баримт бичиг, стандарт, технологийн даалгавар, тоног төхөөрөмжийн паспорт, техникийн нөхцөл, инженер хайгуулын судалгаанд үндэслэсэн, зураг төсөлд экспертизийн магадлал хийгдсэн.	0	30		

4	Барилгын тухай хуулийн 11 зүйлийн 11.1.1, 14 дүгээр зүйлийн 14.1.1, 14.1.2 дахь заалт	Угсралтын ажлыг батлагдсан зураг төслийн дагуу гүйцэтгэсэн, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн шаардлагыг хангасан, барилга байгууламжийн материал, хийц, бүтээц, эдлэхүүн нь барилгын ажлын болон ашиглалтын үед иргэдийн эрүүл мэнд, амь нас, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд аюул учруулахгүй, бат бэх тогтвортой байдлыг хангасан.	0	30		
5	Барилгын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх заалт	Угсралтын ажилд хэрэглэсэн материал, бүтээгдэхүүн, хийц, эдлэхүүн нь барилга байгууламжийн норм, нормативын баримт бичиг, зураг төслийн шаардлагыг бүрэн хангасан, хүний амь нас, эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөлөлгүй, чанарыг баталгаажуулсан гарал үүслийн гэрчилгээ, лабораторийн батламжтай, чанарын шаардлага хангасан зориулалтын сав, баглаа, боодол, хаяг, шошготой.	0	20		
6	Барилгын тухай хуулийн 26, 30 дугаар зүйл	Барилгын ажил эхлэх үргэлжлүүлэх зөвшөөрөл авсан, барилгын ажлын зөвшөөрөл нь хууль тогтоомжид нийцсэн, зөвшөөрлийг ажил эхлэхээс өмнө олгосон, зөвшөөрөл холбогдох мэдээллүүд бүрэн, үнэн зөв тусгагдсан.	0	10		
7	Барилгын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх заалт, 40 дүгээр зүйлийн 40.1.17 дахь заалт	Угсралтын ажлын явцад анхны зураг төслөөс өөрчлөгдөж гүйцэтгэсэн үе шатны ажил бүрд гүйцэтгэлийн зураг төсөл боловсруулж зохиогчоор баталгаажуулсан, материалд өөрчлөлт орсон нөхцөлд зураг төсөл зохиогчоос зөвшөөрөл авсан.	0	20		
8	Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйл	Захиалагчийн хяналт тогтмол хийдэг, захиалагчийн эрх, үүргээ хэрэгжүүлэн ажилладаг.	0	10		
9	Барилгын тухай хуулийн 38 дугаар зүйл	Зураг төсөл зохиогч тогтмол хяналт тавьдаг, зохиогчийн эрх, үүргээ хэрэгжүүлэн ажилладаг.	0	10		
10	Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 тогтоол	Дотоод хяналтын нэгжтэй, дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам батлуулан мөрдөж ажилладаг, дотоод хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлдэг.	0	10		
11	Барилгын тухай хуулийн 42 дүгээр зүйл	Барилгын тухай хуулийн 10.1.4, 10.1.5-д заасан ангилалд хамаарах барилга байгууламжийн үйл ажилла-гаанд зөвлөх үйлчилгээг заавал авсан.	0	10		
	Барилгын тухай хуулийн 37.1.4 дэх заалт	Захиалагч, зураг төсөл зохиогч, угсралтын ажлын гүйцэтгэгч байгууллагууд хоорондоо гэрээ байгуулсан, гэрээний нөхцөл шаардлагууд нь хууль тогтоомжид нийцсэн.	0	5		

13	Барилгын тухай хуулийн 37, 38, 40 дүгээр зүйл	Угсралтын ажлын үе шат тутамд ил, далд ажлын актыг бичиж холбогдох инженерээр баталгаажуулсан, гэрэл зураг хавсаргасан.	0	5		
14	Барилгын тухай хуулийн 37, 38, 40 дүгээр зүйл	Талбайн журналыг өдөр тутам стан-дартын дагуу хөтөлж, баталгаажуулсан.	0	5		
Материалын чанар аюулгүй байдалтай холбогдсон асуултууд			0	40	0	0
15	Барилгын тухай хуулийн 13 дугаар зүйл, "Дулааны сүлжээ" БНБД 41-05-18, "Дулааны сүлжээ" БНБД 41-02-13	Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн материал нь зураг төслийн болон норм, дүрэм стандартын шаардлага хангасан, тохирлын гэрчилгээтэй.	0	10		
16		Суурь, тулгуур зэрэгт хэрэглэсэн бетон зуурмагийн бат бэхийг итгэмжлэгдсэн лабораторийн туршилт шинжилгээгээр баталгаажуулсан.	0	10		
17		Дулаалгын материал нь зураг төсөл, норм дүрмийн шаардлага хангасан	0	5		
18		Байгаль цаг уурын нөхцөлд тохирох нь батлагдсан импортын материал эдэлхүүн хэрэглэсэн.	0	5		
19		Стандарт тогтоогдоогүй шинэ бүтээгдэхүүнийг холбогдох байгууллагын дүгнэлттэй хэрэглэсэн.	0	10		
Угсралтын үйл ажиллагаатай холбогдсон асуултууд			0	85	0	0
20	"Барилгын тухай" хуулийн 11, 14 дүгээр зүйл, "Дулааны сүлжээ" БНБД 41-05-18, "Дулааны сүлжээ" БНБД 41-02-13	Инженер геологийн судалгаа, дүгнэлт-тэйгээр угсралтын ажлыг гүйцэтгэсэн.	0	5		
21		Шугам хоолойн суваг камер, худаг, тулгуурын хийц бүтээц нь зураг төсөлтэй нийцсэн.	0	5		
22		Шугам хоолойн налуу нь зураг төсөл, норм дүрэмтэй нийцсэн.	0	5		
23		Шугам хоолойн хөдөлгөөнтэй болон хөдөлгөөнгүй тулгуурууд зураг төсөл, норм дүрийн шаардлага хангасан.	0	5		
24		Хаалт арматур, ус юүлэх, хий авах, хамгаалах төхөөрөмжүүд зураг төсөл, норм дүрмийн дагуу суурилагдсан.	0	5		
25		Компенсатор, компенсаторын таталт нь зураг төсөл, норм дүрмийн шаардлага хангасан.	0	5		
26		Суваг камер, шугам хоолойн нягтруулга, зэврэлтээс хамгаалах ажлууд хийгдсэн.	0	5		
27		Тууш гагнаастай хоолойн гагнаас нь дээшээ харсан, шугам хоолойн гагнаас нь хана хашлаг хийц, тоног төхөөрөмжийн хоорондох зай хэмжээ нь зураг төсөл, норм дүрмийн шаардлага хангасан.	0	5		
28		Угсралтын ажлыг гүйцэтгэхдээ бусад инженерийн шугам сүлжээтэй огтлолцсон хэсэгт холбогдох байгуул-лагын төлөөллийг байлцуулсан.	0	5		
29		Гагнуурын ажлын чанар шаардлага хангасан, гагнуурын технологи, формуляр үйлдсэн.	0	20		

30		Худаг ба камер, худгийн амыг хучилтын гадаргуугаас дээш 4-5 см-д суулгасан, худаг камерт зориулалтын шат угсрагдсан.	0	5		
31	"Барилгын тухай" хуулийн 11, 14 дүгээр зүйл, "Дулааны сүлжээ" БНБД 41- 05-18, "Дулааны сүлжээ" БНБД 41-02-13	Насос, хөдөлгүүрийн тоо хэмжээ, хүчин чадал зураг төсөл, норм дүрмийн шаардлага хангасан.	0	5		
32		Хянах хэмжих хэрэгсэл нь зураг төслийн дагуу бүрэн суурилагдсан, баталгаажилт хийгдсэн.	0	5		
33		Тохируулах болон автомат удирдлагын систем зураг төслийн дагуу хийгдсэн, ажиллагаа хэвийн.	0	5		
Цахилгааны ажилтай холбогдсон асуултууд			0	40	0	0
34	Цахилгаан байгууламжийн дүрэм БД-43-101-03	Газардуулгын ажил норм дүрмийн дагуу хийгдсэн.	0	10		
35		Цахилгааны кабель утасны уулзвар зангилааны холболт, угсралт хэвийн.	0	10		
36		Цахилгааны шитны самбар, хайрцаглалт хэвийн бөгөөд галаас хамгаалах арга хэмжээ хангалттай.	0	10		
37		Цахилгаан тоног төхөөрөмж, шугамын ажлын гүйцэтгэл нь зураг төсөлтэй нийцсэн.	0	10		
Туршилт, сорилт, тохируулга зүгшрүүлэлттэй холбогдсон			0	60	0	0
38	"Дулааны сүлжээ" БНБД 41- 05-18, "Дулааны сүлжээ" БНБД 41-02-13, "Уурын бас ус халаалтын зуухыг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм", "Даралтат савыг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм", "Уур, халуун усны шугам хоолойг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм"	Тоног төхөөрөмж, шугам хоолойд усан сорилт хийсэн.	0	20		
39		Тоног төхөөрөмж, шугам хоолойд дотоод үзлэг, металл, гагнуурын шалгалт, шинжилгээ хийгдсэн.	0	20		
40		Тоног төхөөрөмж, шугам хоолойд угаалт, үлээлгэ, халуун, хүйтэн байдлаас ажиллуулж туршилт хийсэн, туршилтын үр дүн хангалттай.	0	20		
НИЙТ ОНОО			0	450	0	0

БАТАЛГААЖУУЛАЛТ		
Хяналтын чиглэл, албан тушаалын нэр	Хяналтын чиглэл, албан тушаалын нэр	Хүлээн зөвшөөрсөн: Аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий албан тушаалтан
/ овог, нэр/	/ овог, нэр/	/ овог, нэр/
/ гарын үсэг, тэмдэг/	/ гарын үсэг, тэмдэг/	/ гарын үсэг, тамга/

Тайлбар:

ГҮЙЦЭТГЭЛИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ		
Хяналтын чиглэл, албан тушаалын нэр	Хяналтын чиглэл, албан тушаалын нэр	Хүлээн зөвшөөрсөн:
/ овог, нэр/	/ овог, нэр/	/ овог, нэр/
/ гарын үсэг, тэмдэг/	/ гарын үсэг, тэмдэг/	/ гарын үсэг, тамга/

Тайлбар: